

# УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

## МОНГОЛ ХЭЛ

### V АНГИ

Аймаг/дүүрэг: .....

Сум: .....

Сургууль: .....

Анги: ..... Бүлэг: .....

Овог: .....

Нэр: .....

#### САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 60 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

## Халуун цай

Одмаа, Одхүү хоёр зуслан руугаа явж байв. Тэдний замд гишүү үүрсэн нэгэн эмгэн тааралдав. Эмгэн хэд алхсанаа л хөлсөө байн байн арчин, амьсгаагаа дарж, өвдгөө тулан зогсоно.

- Одхүү, Чи хүлээж байгаарай. Тэр эмээд туслах хэрэгтэй! гэж хэлэнгүүтээ Одмаа гүйж одов.
- Хаачих нь вэ чи? гэж Одхүү хойноос нь хашхирснаа “Аль тааралдсан бүхэнд туслах гэдэг ч гайгүй байна даа” гэж нэмж хэлэх нь сонсогдлоо. Одмаа түүний хэлэхийг тоолгүй эмгэний үүрсэн гишүүг гэрт нь хүргэж өгөв.

Энэ явдлаас хэд хоногийн дараа хүүхдүүд жимс түүхээр ойд явцгаав. Их үдийн наран эгц дээрээс төөнөж, биеийн ил хэсгүүд улайж харагдана. Ам нь жигтэйхэн их цангажээ. Уулын бэлд хэдэн гэр сувд адил цайрч харагдлаа. Одхүү бүхнээс урьтаж, уух юм гуйхаар гүйв.

Гэрийн гадаа ааруул тавьж байгаа хөгшнийг харвал нөгөө гишүү үүрч явсан эмгэн байв.

- Хүү минь усаар яах гээ вэ? Амны цангаа гардаггүй юм. Халуун цай уу! гэж уриалгахан хэлээд, сайхан цай аягалан өгөв. Бас хатсан ааруулаас атга атгаар өгөв.

Одхүү гэмшсэндээ эмгэний өгсөн халуун цайг түргэн түргэн оочилж уугаад, бүгдээс түрүүнд:

- Танд маш их баярлалаа гэж хэлмэгцээ гүйх шахам гэрээс гарав.

Тусч эмгэний халуун цай, өөрийн аминч зан хоёр Одхүүд нэг л жигтэйхэн санагдаад, аминч зангаа орхиё байз гэж боджээ.

1. Одхүү, эмгэний гэрээс яаран гарах болсны учрыг эхийн эхлэл хэсгээс олж бичээрэй. **/2 оноо/**

.....

.....

.....

.....

2. А. Эхийн үйл явдал ямар улиралд болж байна вэ? **/1 оноо/**

.....

- Б. Хариултаа батлах жишээ өгүүлбэр хоёрыг эхээс олж бичээрэй. **/2 оноо/**

.....

.....

.....

3. А. Одмаагийн хийсэн үйл, хэлсэн үгийг ялган бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

Б. Одмаагийн хийсэн үйл, хэлсэн үгэнд үндэслэн зан чанарыг тодорхойлж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

4. Хүснэгтэд Одхүүгийн зан чанарын өөрчлөлтийг дүгнэн бичээрэй. /3 оноо/

Эхлэл хэсэгт ямар зан чанартай байсан бэ?	Төгсгөл хэсэгт ямар зан чанартай болсон бэ?
<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>Яагаад өөрчлөгдөх болсон бэ?</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	

5. Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж бичээд, яагаад өгүүлбэрийг сонгосноо өөрийн үгээр тайлбарлана уу. **/3 оноо/**

.....

.....

.....

.....

6. “Дурсамж дүүрэн 9-р сарын 1” сэдвээр өөрт тохиолдсон явдлаа 100-120 үгэнд багтаан бичээрэй.

Бичихдээ:

- Эхлэлт хэсэгт – Үйл явдал өрнөсөн орчныг дүрслэн бичээрэй.
- Гол хэсэг – Өөрт тохиолдсон, болсон явдлыг бичих
- Төгсгөл хэсэгт – Өөрт тохиолдсон явдлаар дамжуулан бусдад ямар сургамжит санаа өгч болох вэ?

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

A series of 25 horizontal dotted lines for writing.